

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

<u>2022 оны 05 сарын 03 едер</u> Дугаар <u>А/228</u>

Арвайхээр

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.4, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай" 9 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн дүн, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" 07/021 дүгээр тогтоолоор батлагдсан "Өвөрхангай аймгийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө"-ний 2.4, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогын ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын бүрэлдэхүүнийг 1 дүгээр, улсын үзлэг, тооллогын ажилд зарцуулагдах зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын дарга (И.Доржсүрэн)-д ДААЛГАХ нь:

2.1.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргах:

2.2.Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогод хамрагдах хуулийн этгээдийн нэр, өмчлөлийн хэлбэр, регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар болон холбогдох мэдээллийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гарган, тооллогын ажилд ашиглах;

2.3.Улсын болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн, орон нутгийн өмчид бүртгэлтэй эд хөрөнгийг тооллогод бүрэн хамруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах:

2.4.Улсын үзлэг тооллогын ажилтай хамтатган орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа ашиглалтгүй болон илүүдэлтэй үндсэн хөрөнгө, ашиглалтын хугацаа дууссан цаашид ашиглах боломжтой эд хөрөнгийг газар дээр нь үзэн тоолж, худалдах, шилжүүлэх, акт тогтоон устгах, ашиглалтын хугацааг сунгах талаар дүгнэлт гаргах, хөрөнгийн ангиллыг зөв тогтоож данс хооронд шилжүүлэх ажлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.5.Орон нутгийн өмчид бүртгэлтэй бусдын буруутай үйлдлээс эвдэрсэн, шамшигдуулсан хөрөнгөд акт тогтоон зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

2.6.Орон нутгийн өмчийн тооллогын нэгдсэн дүн мэдээг боловсруулан гаргаж, 2022 оны 08 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах;

2.7.Орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын аймгийн дүн мэдээг нэгтгэн 2022 оны 08 дугаар сард багтаан улсын нэгтгэлд хамруулах.

3.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн мэдээллийг нэгтгэн гаргаж, аймгийн тооллогын комисст хүргүүлэх, улсын бүртгэл дэх мэдээллийг тооллогод хамрагдсан дүнтэй тулган баталгаажуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар цаашид авах арга хэмжээний санал боловсруулан танилцуулахыг аймгийн салбар комиссын дарга (И.Доржсүрэн), "Өвөрхангай аймгийн Автотээврийн төв"-ийн дарга (Д.Амартүвшин) нарт тус тус даалгасугай.

4.Орон нутгийн өмчит (өмчийн оролцоотой) хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

4.1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу өөрийн байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг тооллогод хамруулах бэлтгэлийг хангаж, тооллогын комисс томилон, тооллогын ажлыг 2022 оны 05 дугаар сарын 15ны өдрийн дотор багтаан гүйцэтгүүлэх;

4.2.Төрийн мэдээллийн сан (e-mongolia)-г ашиглан өөрийн байгууллагын эзэмшил ашиглалтад байгаа газар, үл хөдлөх хөрөнгө, автотээврийн хэрэгслийн бүртгэлийг нягтлан шалгаж, бүртгэлд хамруулах, тулган баталгаажуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авах;

4.3.Аймгийн салбар комиссын удирдамж, зааврын дагуу тооллогын дүн, тайланг бэлтгэн аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ажлын хэсэгт хянуулах, 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээлгэн өгөх, зохион байгуулалтын арга хэмжээ авах.

5.Батлагдсан 12,227,550 (арван хоёр сая хоёр зуун хорин долоон мянга таван зуун тавь) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

6.Улсын үзлэг, тооллогын хяналтын тооллогын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон ажилтнуудыг тооллогын хугацаанд ажлаас бүрэн чөлөөлж, ажиллах нөхцөлөөр хангахыг холбогдох байгууллагуудын дарга, эрхлэгч нэрт даалгасугай.

А.ИШЛОРЖ ЗАСАГ ДАРГА

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН УЛСЫН ҮЗЛЭГ ТООЛЛОГЫН АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЙМГИЙН САЛБАР КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: И.Доржсүрэн (аймгийн Засаг даргын Орлогч) Гишүүд: 3.Балданням (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Д.Шивааннүрдэв (аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга)

Н.Чимэддорж-Ойдов (аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Т.Ариунболд (аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Т.Цэдмаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Д.Амартүвшин (Өвөрхангай аймгийн Автотээврийн төвийн дарга)

Нарийн бичгийн дарга: М.Нинжбадгар (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн)

> Г.Ариунаа (аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтэн)

> > -000-

9

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН УЛСЫН ҮЗЛЭГ, ТООЛЛОГЫН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД ЗАРЦУУЛАГДАХ ЗАРДАЛ

| Д/д | Зардлын зүйл | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|----------------------|------------------------------------|------------------------------------|----------------|---------------------------|----------------|
| | 1.Сумдад ажил | | | рдал | |
| 1 | Бичгийн цаас | боодол | 10 | 18,000 | 180, 000 |
| 2 | | ширхэг | 4 | 85,000 | 340,000 |
| 3 | Принтерийн хор цэнэглэх | ширхэг | 4 | 15,000 | 60,000 |
| 4 | Принтерийн хор (өнгөт) | ширхэг | 2 | 85,000 | 170,000 |
| 5 | Фото цаас | боодол | 4 | 30,000 | 120,000 |
| 6 | Хавтас | ширхэг | 19 | 5,500 | 104,500 |
| 7 | Бал | ширхэг | 20 | 1,500 | 30,000 |
| | Дүн | | | | 1,004,500 |
| | 2.Сумдад ажи | ллах томил | юлтын зар | дал | |
| Nº | Ажлын хэсэг | Хүн | Хүн/ хоног | нэг өдрийн томилолт | |
| 1 | Томилолт (1 дүгээр ажлын хэсэг) | 5 | 27 | 26,500 | 3,577,500 |
| 2 | Томилолт (2 дугаар ажлын хэсэг) | 5 | 27 | 26,500 | 3,577,500 |
| | Дүн | | | | 7,155,000 |
| | 3.Тээвэр | шатахуунь | а зардал | | |
| Nº | Явах газар | Сум хоорон дын зай км-ээр | норм (литр) | Нэгжийн үнэ | нийт зардал |
| 1 дүгээр ажлын хэсэг | Арвайхээр-Зүүнбаян-Улаан (50км) | 50 | 11 | 2,700 | 29,700 |
| | Зүүнбаян-Улаан-Бат-Өлзий (75км) | 75 | 17 | 2,700 | 44,550 |
| | Бат-Өлзий-Хужирт (60 км) | 60 | 13 | 2,700 | 35,640 |
| | Хужирт-Хархорин (55 км) | 55 | 12 | 2,700 | 32,670 |
| | Хархорин-Бүрд (130км) | 130 | 29 | 2,700 | 77,220 |
| | Бүрд-Есөнзүйл (40км) | 40 | 9 | 2,700 | 23,760 |
| | Есөнзүйл-Арвайхээр (100км) | 100 | 22 | 2,700 | 59,400 |
| | Арвайхээр-Өлзийт (90км) | 90 | 20 | 2,700 | 53,460 |
| | Өлзийт-Баян-Өндөр (50км) | 50 | 11 | 2,700 | 29,700 |
| | Баян-Өндөр- Сант (55км) | 55 | 12 | 2,700 | 32,670 |
| | Сант-Баянгол (76км) | 80 | 18 | 2,700 | 47,520 |
| | Баянгол-Арвайхээр (80км) | 80 | 18 | 2,700 | 47,520 |
| | Нөөц шатахуун (500 км) | 500 | 110 | 2,700 | 297,000 |

| | | 3 | | 8 | |
|-------------------------|---------------------------------------|------------------------|------|-------------------|----------------|
| дугаар ажлын хэсэг | Арвайхээр-Төгрөг (95км) | 95 | 21 | 2,700 | 56,430 |
| | Төгрөг-Гучин-ус (50км) | 50 | 11 | 2,700 | 29,700 |
| | Гучин-ус-Богд (100км) | 100 | 22 | 2,700 | 59,400 |
| | Богд-ББУлаан (100км) | 100 | 22 | 2,700 | 59,400 |
| | ББУлаан-Баянтээг (60км) | 60 | 13 | 2,700 | 35,640 |
| | Баянтээг-Арвайхээр (125км) | 125 | 28 | 2,700 | 74,250 |
| | Арвайхээр-Хайрхандулаан (75км) | 75 | 17 | 2,700 | 44,550 |
| ap ax | Хайрхандулаан-Нарийнтээл (60км) | 60 | 13 | 2,700 | 35,640 |
| дугаа | Нарийнтээл-Жаргалант (90км) | 90 | 20 | 2,700 | 53,460 |
| 2 | Жаргалант-Уянга (50 км) | 50 | 11 | 2,700 | 29,700 |
| | Уянга-Тарагт (30км) | 30 | 7 | 2,700 | 17,820 |
| | Тарагт-Туяа баг (35км) | 35 | 8 | 2,700 | 20,790 |
| | Туяа баг-Арвайхээр (40км) | 40 | 9 | 2,700 | 23,760 |
| | Нөөц шатахуун (500 км) | 500 | 110 | 2,700 | 297,000 |
| 3 дугаар ажлын хэсэг | Арвайхээр дотор (400км) | 400 | 88 | 2,700 | 237,600 |
| | Арвайхээр- Улаанбаатар | 900 | 198 | 2,700 | 534,600 |
| | Техник үйлчилгээ (тослох материал) | | 65 | 10,500 | 682,500 |
| | Дүн | | | | 3,103,050 |
| | 4. Cyp | огалтын за | рдал | | |
| Nº | Материалын нэр | Оролцо гчдын тоо | удаа | нэгжийн зардал | Нийт зардал |
| 1 | Цайны материал | 430 | 1 | 1,500 | 645,000 |
| 2 | 2 багш (хоол) | 2 | 4 | 40,000 | 320,000 |
| | Дүн | | | | 965,000 |
| 1 | Бичиг хэрг | 1,004,500 | | | |
| 2 | Томилол | 7,155,000 | | | |
| 3 | Тээвэр шатахуун, тосл | 3,103,050 | | | |
| 4 | Сургалты | 965,000 | | | |
| | 12,227,550 | | | | |

3

-000-